

## **ТӨРИЙН АЛБА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР ИРГЭДЭЭС АВСАН САНАЛ АСУУЛГЫН НЭГДСЭН ДҮНГИЙН ТАЛААРХ ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ**

Санал асуулгад тус аймгийн 394 иргэн хамрагдан хариулт өгсөн байна.

Хууль тогтоомж, Засгийн газрын болон Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийн талаар иргэдээс хууль тогтоомжийн мэдээлэл, сургалт сурталчилгаа, хэрэгжилтийн байдлын талаар санал асуулгад оролцогсдын 31.9-41.9 хувь нь бүрэн хангалттай, хангалттай, 5.8-23.6 хувь нь төдийлөн хангалттай бус, хангалтгүй гэж хариулсан, хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны шударга байдлын асуулт тавьж хариулт авахад 23.6-27.1 хувь нь хангалттай, бүрэн хангалттай гэж хариулсан бол 14.2-27.1 хувь төдийлөн хангалттай бус, хангалтгүй гэж хариулжээ.

Дээрх хариултаас үзэхэд хууль тогтоомж шийдвэрийн сургалт сурталчилгааг улам сайжруулах, хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны шуурхай шударга байдлыг хангах талаар анхаарч ажиллах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд өнөөгийн Засгийн газрын үйл ажиллагааг иргэд хэрхэн үнэлж байгаа, ядуурлын бууруулах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний чанар хүртээмж, үйлдвэржүүлэлтийг дэмжих жилийн ажлын үр дүнгийн талаар 3 асуулт тавьж хариулт авахад санал асуулгад оролцсон иргэдийн 28.6-36.8 хувь нь өнөөгийн Засгийн газрын үйл ажиллагааг хангалттай, бүрэн хангалттай, 9.6-20.5 хувь нь төдийлөн хангалттай бус, хангалтгүй гэж үнэлсэн байна.

Ядуурлын бууруулж өрхийн орлогын нэмэгдүүлэх талаар Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг санал асуулгад оролцсон иргэдийн 27.6-43.4 хувь нь хангалттай, бүрэн хангалттай гэж үзсэн бол 22.3 хувь нь төдийлөн хангалттай бус, хангалтгүй гэж дүгнэсэн байна. Үүнээс үзэхэд иргэдийн ядуурлын бууруулах, өрхийн орлогыг нэмэгдүүлэх талаар авч байгаа арга хэмжээг нааштай үнэлж байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Харин үйлдвэржүүлэлтийг дэмжих жилийн ажлын үр дүнг санал асуулгад оролцсон иргэдийн 74.6 хувь нь хангалттай, бүрэн хангалттай гэж үнэлж дүгнэсэн бол 20 хувь нь төдийлөн хангалттай бус, хангалтгүй гэж үзсэн байна.

Аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн чиглэлээр 4 асуулт тавьж хариулт авсаны дотор үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт сумдад хэр зэрэг байгаа талаар иргэдээс асуухад иргэдийн 78.6 хувь хангалттай, бүрэн хангалттай гэж үнэлсэн бол 19 хувь нь төдийлөн хангалттай бус, хангалтгүй гэж үнэлсэн байна. Үүнээс үзэхэд аймаг, сумдын Засаг дарга нарын хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилтэд иргэд илүү сэтгэл ханамжтай байдаг нь харагдаж байна.

Тус аймагт 2009 онд дэвшүүлэн тавьсан “Төрийн албан хаагчдын ажлын сахилга хариуцлагыг дээшлүүлэх жил”ийн хүрээнд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийн байдалд санал асуулгад оролцсон иргэдийн 79.4 хувь нь хангалттай, бүрэн хангалттай гэж үнэлж дүгнэж байгаа бол 15.2 хувь нь төдийлөн хангалттай бус, хангалтгүй гэж хариулсан байдлаас үзэхэд энэ ажил зохих үр дүнгээ өгчээ гэж үзэж болохоор байна.

Мөн тус аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн “Өрх бүр үйлдвэрлэгч-үйлчлэгч -II” хөдөлгөөн хэрхэн өрнөж байгаа талаар болон сумдад

төмс, хүнсний ногоо хэр зэрэг тариалж байгаа талаар иргэдээс асуухад иргэдийн 78.3-79.1 хувь нь хангалттай, бүрэн хангалттай гэж хариулсан бол 8.9-9.6 хувь нь төдийлөн хангалттай бус, 8.6-9.4 хувь нь хангалтгүй гэж хариулснаас үзэхэд энэ хөдөлгөөнийг илүү өргөн хүрээнд олны хамруулан эрчимтэй зохион байгуулах төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх шаардлагатай шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Аймаг, сумын Засаг даргаас иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээний чанар хүртээмж хэр зэрэг байгаа талаар дараах 4 асуултад хариулт авахад:

Сумдын төрийн байгууллагуудад ил тод, шударга байдал хэрхэн хангагддаг талаар иргэдээс асуухад 34.5-37.5 хувь нь хангалттай, бүрэн хангалттай гэж хариулсан бол 6.8-17.0 хувь төдийлөн хангалттай бус, хангалтгүй гэж хариулжээ. Харин Та хүссэн үедээ эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ авч чадаж байна уу гэсэн асуултад санал асуулгад оролцогсдын олонх нь буюу 81.9 хувь нь хариулсанаас үзэхэд тус аймгийн эрүүл мэндийн байгууллагууд иргэдэд анхан шатны тусламж үйлчилгээг хүргэх талаар сайн ажиллаж ирснийг харуулж байна.

Тус аймагт иргэд стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнээр хэрхэн хангагдаж буй талаар асуухад санал асуулгад оролцсон иргэдийн 32.2-47.9 хувь нь хангалттай, бүрэн хангалттай гэж хариулсан бол 16.5 хувь нь төдийлөн хангалттай бус, хангалтгүй гэж хариулснаас үзэхэд стандартын шаардлага хангасан эрүүл хүнсний бүтээгдэхүүнээр цаашид хангах талаар анхаарах шаардлага хэвээр байгаа нь харагдаж байна.

Сумдын ариун цэвэр тохижилтын талаар иргэдээс асуухад иргэдийн 27.1-51.8 хувь нь хангалттай, бүрэн хангалттай гэж хариулсан бол 18.2 хувь нь төдийлөн хангалттай бус, хангалтгүй гэж хариулсанаас үзэхэд өнгөрсөн онд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээнд туссан сумдын төвийн ариун цэвэр, тохижилтыг сайжруулах талаар хүлээсэн үүргээ сумдын Засаг дарга нар биелүүлэх талаар багагүй санаачлага гарган ажиллаж ирсэн нь харагдаж байна.

Аймгийн 70 жилийн ой угтаж аймаг орон нутагтаа ямар ажил зохион байгуулаасай гэж хүсч байгаа талаар иргэдээс асуухад дараах ажил асуудалд түлхүү анхаарч үр дүнд хүргээсэй гэж хүсч байгаа нь харагдаж байна.

1. Улаанбаатар-Мандалговийн хооронд хатуу хучилттай засмал тавих ажлыг түргэвчлэх, аймгийн төв сумдын хоорондох замыг сайжруулж тэмдэгжүүлэх

2. Бүх сумдыг интернетийн сүлжээтэй болгож мэдээ мэдээллийн шуурхай байдлыг хангах

3. Аймгийнхаа нутагт байгаа байгалийн баялгаа ашиглаж эдийн засгийн эргэлтэнд оруулах ажлыг түргэвчлэх

4. Аймаг, сумдын төвд мод тарьж зүлэгжүүлэх ажлыг үргэлжлүүлэн хийх

5. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл хөгжүүлж, энэ чиглэлийн жижиг дунд үйлдвэр олноор байгуулах замаар залуучуудыг ажлын байраар хангах

6. Сумдын төвд орон сууц барьж, төрийн албан хаагчид, иргэдийг тохилог орон сууцаар хангах

7. Аймаг сумдын төвийн тохижилт соёлжилтыг сайжруулах /Барилга байшин, гэр хорооллын хашаа гудамжны эмх цэгц, гэрэлтүүлэг сайжруулах, хог хаягдлын асуудлыг шийдэх/

8. Аймаг сумын төвд сүү, цагаан идээний төрөлжсөн зах, дэлгүүр ажиллуулах

9. Аймаг сумдын төвийг төвлөрсөн халаалт, цэвэр бохир усны холболттой болгох

/ Төвлөрсөн дулааны станц барьж байгуулах/

10. Аймаг, сумын төвийг сүү цагаан идээгээр хангах зорилгоор үхрийн фермерийн аж ахуй байгуулах санаачилгыг дэмжиж ажиллах

11. Сумдыг мэргэжилтэй боловсон хүчнээр хангаж, тогтвор суурьшилтай ажиллуулах

12. Хүрэн нүүрснээс бензин гаргах ажлыг түргэвчлэх

13. Аялал жуулчлал хөгжүүлэх, түүх соёлын дурсгалт газруудыг тохижуулах

14. Зууны манлай уртын дууч Ж.Дорждагвын театрыг Сайхан-Овоо сумын Цогт ууланд байгуулах

Малчдын амжиргааны түвшинг дээшлүүлэх талаар иргэд ямар санал бодолтой байдаг талаар санал авахад:

1. Мал, мах, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн үнийг тогтворжуулах

2. Малчдын бүлэг хоршоог төрөөс дэмжин төсөл хөтөлбөрт хамруулах замаар дэмжлэг үзүүлэх

3. Мах, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр орон нутагт байгуулах, сум бүрт мах сүү, цагаан идээний төрөлжсөн дэлгүүртэй болгох

4. Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг ченжээр дамжуулахгүй нэгдсэн журмаар авдаг тогтолцоо буй болгох / Малын түүхий эдийн зах ажиллуулах, биржийн сүлжээ бий болгох гэх мэт/

5. Сайн малчны арга туршлагаас залуу малчдад суралцуулах, амьдрах ухааны сургалт сурталчилгааны ажлыг өргөжүүлэх

6. Малын тэжээлийн ургамал тариалуулах, малчдыг хямдруулсан өвс тэжээлээр хангах ажил зохион байгуулах

7. Өндөр ашиг шимтэй мал өсгөх, ялангуяа мах сүүний чиглэлийн шилмэл сүрэгтэй болох талаар бодлогын чанартай ажил зохион байгуулах

8. Мал, мах гадаадад экспортод гаргадаг болох

9. Малгүй буюу цөөн малтай иргэдийг малжуулах төсөл хөтөлбөрт хамруулах, тэднээр төмс хүнсний ногоо тариулах ажил зохион байгуулах

10. Цаг агаарын эрсдэлээс хамгаалах сан байгуулах

11. Бэлчээр хуваарьтай ашиглах, бэлчээр хаших ажлыг өргөтгөх

12. Малчдын хөдөлмөрийг үнэлэх, тэднийг НД, ЭМД-д хамруулах, НДШ-ийг төрөөс төлдөг болох

13. Мал эмнэлэгийн үйлчилгээг сайжруулах

14. Малчдын хүүхдийг оюутны сургалтын төлбөрөөс чөлөөлөх

15. Аймаг, сум дундын отрын бүс нутаг байгуулах

16. Малчдын өвөлжөө хаваржаанд төмс, хүнсний ногоо тариулах ажлыг дэмжих

17. Малчдыг бага хүүтэй, хөнгөлөлттэй зээлээр дэмжих

18. Аймгийн айраг, мах, ингэний хоормог зэрэг нэр хүндтэй брендийг улс орон даяар сурталчлах

19. Малчдыг эрүүл мэндийн үзлэг оношилгоонд тогтмол хамруулж байх

20. Багийг хөгжүүлж багийн Засаг дарга нарын хариуцлагыг дээшлүүлэх

Тус аймагт тулгамдаж байгаа асуудлын нэг цөлжилтийг сааруулах талаар ямар ажил хийгээсэй гэж хүсдэг вэ гэсэн асуултад иргэд дараах асуудлуудад анхаарал хандуулаасай гэж хүсч байгаагаа илэрхийлжээ.

1. Талхлагдсан бэлчээрт олон наст ургамал цацах, мод /заг/ бут сөөг тариалах ажлыг дэмжих / Зүлэг ногоо, олон настын үр үнэгүй буюу хөнгөлөлттэй үнээр олгох/ зарим бүс нутагт газар тариалан эрхлүүлэх
2. Жил бүр айл өрх, албан байгууллага, иргэн бүрээр жимсний мод, бут сөөг тариалах хөдөлгөөнийг аймаг сумдад өрнүүлж, үр дүнг тооцож ажиллах, хөнгөлөлт урамшуулал олгох асуудлыг шийдэх
3. Бэдчээр усжуулж худаг гаргах, булаг шанд усны эхэд мод бут сөөг тарих,
4. Байгаль орчинтой зөв харьцах талаар сургалт сурталчилгааны ажлыг өргөжүүлэх
5. Бэлчээр хашиж хамгаалах ажлыг өргөтгөж, бэлчээрийн ургамал тариалах, бэлчээрийг хуваарьтай ашиглуулах талаар анхаарах
6. Шинээр суурин МАА буй болгох , бэлчээрийн болон суурин МАА-г зөв зохистой хослон хөгжүүлэх
7. Аймаг сумын төвд ногоон бүс, ойн зурвас байгуулахыг бүх талаар дэмжих
8. Үүлэнд нөлөөлж хур бороо оруулах ажлыг зөв зохион байгуулах
9. Байгаль орчны нөхөөн сэргээлтийг уул уурхайн компаниудаар тухай бүр хийлгэж байх
10. Малын тоо толгойг бэлчээрийн даацад нийцүүлэх цөөрүүлэх бодлого барьж, ашиг шим өндөр цөөн тооны малтай байхын ач холбогдлыг малчдад ойлгуулах ажил зохион байгуулах
- 11.. Ногоон хүрэм хөтөлбөрийн хэрэгжилтийг үр дүнтэй чанартай болгох талаар анхаарах
12. Гялгар уутыг аймгийн хэмжээнд хэрэглээнээс хасах
13. Мал аж ахуйн бүлэг, хоршоог бүх талаар дэмжих
14. Бут, дэрсний элсийг зайлуулах ажил зохион байгуулах
15. Цөлжилтийн байдлыг олон улсын түвшинд бодитой танилцуулж тэдний зүгээс дэмжлэг авах талаар анхаарах
16. Бут сөөгийг түлшинд хэрэглэхийг хориглох

Аймаг, сумын хөгжилд юу саад болж байгаа талаар иргэдээсээ асуухад дараах хариултыг түлхүү өгч байгаа нь харагдлаа.

1. Аймагт нүүрлээд байгаа цөлжилт
2. Цаг агаарын хүндрэл бэрхшээл /Ган зуд/
3. Ажилгүйдэл, ядуурал
4. Архидалт
5. Намаар талцсан улс төржилт
6. Залхуурал , бэлэнчлэх сэтгэлгээ
7. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод бус байдал, хүнд суртал, чирэгдэл
8. Төрийн албан хаагчдын ажлын хариуцлага сул
9. Хөрөнгө санхүүгийн дутагдал, захиран зарцуулах эрх мэдэл орон нутагт дутмаг
10. Удирдлагын хэт төвлөрсөн тогтолцоо, орон нутгийн хурлын эрх мэдэл дутмаг
11. Иргэдийн оролцоо хангалтгүй, идэвхгүй байдал
12. Авилгал

САНАЛ АСУУЛГЫН ДҮНГ НЭГТГЭСЭН:  
ХШҮ-НИЙ ТАСГИЙН ДАРГА

Г.ЦЭРЭНДОРЖ



Санал асуулгын дүнг нэгтгэсэн:  
ХШҮ-ний тасгийн дарга

/ Г.Цэрэндорж /